



СЕКЮРИТИЗ  
ҮЦК

**ГАДААД ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ**

**2022.04.25-2022.04.29**

---



# ГАДААД ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2022.04.29-ний after trading session байдлаар

АНУ	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
DOW	33,000.00	0.06%	-3.10%	-5.52%	-3.28%
S&P 500	4,242.45	0.06%	-3.74%	-9.76%	-1.36%
NASDAQ	13,268.00	0.25%	-4.73%	-14.95%	-6.57%
Европ	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
GB100	7,545.00	0.47%	0.30%	-0.45%	8.25%
DE40	14,098.00	0.84%	-0.31%	-3.48%	-6.86%
FR40	6,534.00	0.39%	-0.72%	-3.08%	4.22%
IT40	24,252.00	0.82%	-0.11%	-4.14%	0.46%
ES35	8,652.00	0.85%	-0.79%	0.39%	-2.62%
Ази	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
JP225	26,668.00	-0.67%	-3.16%	-5.55%	-7.39%
SHANGHAI	3,047.00	2.41%	-1.29%	-6.72%	-11.60%
CSI 300	3,929.00	2.43%	0.07%	-5.56%	-22.83%
CH50	13,242.17	1.29%	0.06%	-2.08%	-22.81%
SENSEX	57,197.00	-0.80%	-0.24%	-2.77%	16.97%
Эрчим хүч	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
Газрын тос (Crude Oil)	103.89	-0.75%	5.42%	2.00%	61.08%
Газрын тос (Brent)	109.34	1.63%	2.52%	-1.88%	63.78%
Байгалийн хий	7.4720	3.15%	12.25%	29.22%	152.39%
Шатахуун	3.4721	-0.89%	5.06%	5.65%	67.23%
Нүүрс	326.30	0.08%	0.09%	25.50%	249.73%
Түүхий эд	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
Алт	1,890.13	-0.33%	-0.38%	-2.17%	5.48%
Мөнгө	22.617	-0.55%	-4.13%	-7.64%	-15.78%
Зэс	4.2990	-2.18%	-2.12%	-3.30%	-5.30%
Бонд	Өгөөж	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
АНУ	2.9394	0.0019	0.13%	0.55%	1.34%
Англи	1.9100	0.0350	-0.05%	0.24%	1.07%
Швейцар	0.8350	0.0200	-0.09%	0.14%	1.10%
Испани	1.9760	0.0050	0.05%	0.45%	1.52%
Португаль	2.0250	0.0050	0.39%	0.59%	2.38%

Эх сурвалж: Trading economics

# ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

## Хөрөнгийн зах зээлийн ханшийн хэлбэлзэл энэ ондоо үргэлжлэхээр байна

Өнгөрсөн 7 хоногт олон улсын эдийн засгийн өсөлт эхний улирлын байдлаар саарч байгаа талаарх мэдээлэл анхаарал татлаа. Европын холбооны хувьд Орос-Украины дайн тус бүсийн эдийн засагт хүндрэл учруулсаар байгаа бол БНХАУ-д хөл хорионы улмаас өсөлтийг удаашруулж байна. АНУ-ын эдийн засгийн өсөлт 1.4%-иар агшсан нь шинжээчдийг ихээхэн гайхшируулсан юм. S&P 500 индекс 1 сарын 3-ны оргил үеэсээ 10%-иар унасан бол Nasdaq индекс 20% орчим унаад байгаа юм.

Шинжээчдийн үзэж байгаагаар 2022 онд хөрөнгийн зах зээл ихээхэн хэлбэлзэлтэй байх хүлээлттэй байна. Хэдий ХНС бодлогын хүүг цаашид нэмэх хандлагатай байгаа боловч эрэлт, худалдан авалтын чадвар болон өрхийн санхүүгийн байдал тогтвортой байгаа тул эдийн засгийн хямрал арай болохгүй байх болов уу гэсэн хүлээлттэй байна.



Дээрх зураг нь S&P 500 индексийн сүүлийн 12 сарын ханшийг харуулж байгаа ба эдийн засгийн өсөлт саарч байгаатай холбоотой АНУ-ын хөрөнгийн зах зээл унаж байгааг харуулж байна.

Эх сурвалж: [www.edwardjones.com](http://www.edwardjones.com)

# ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

## 1-р улирлын ДНБ-ний өсөлт сөрөг гарсан боловч эрэлт тогтвортой хэвээр байна

АНУ-ын 1-р улирлын ДНБ-ний түвшин 1.4%-иар агшсан нь өмнөх улирлын 6.9%-ийн өсөлтөөс огцом буурсан нь хүлээлтээс ихээхэн бага байсан юм. Энэхүү эдийн засгийн агшилт нь экспортын удаашрал, түүхий эд материалын зарцуулалт болон засгийн газрын төсвийн зарцуулалт буурсантай холбоотой тайлбарлажээ. Гэсэн хэдий ч АНУ-ын ДНБ-ний 70%-ийг бүрдүүлдэг өрхийн худалдан авалт тогтмол өссөөр байгаа нь дараах хүчин зүйлсээс байж болох юм:

- Үйлчилгээний зарцуулалт нэмэгдсэн нь өрхийн худалдан авалт 2.5%-иас 2.7% болж өсөхөд нөлөөлсөн ба жилд дунджаар 2.3%-иар өсөж иржээ.
- Цар тахлын нөхцөл байдал дээрдэж байгаатай холбоотой хүмүүс үйлчилгээ авах нь ихэссэн тул цаашид өрхийн худалдан авалт өсөх хандлагатай байна.
- Бизнесүүдийн хөрөнгө оруулалт 1 жилийн хугацаанд 9.2%-иар өссөн нь түүхэн дээд үзүүлэлт юм.
- Олон улсад тодорхой бус байдал үүссэн боловч дотоодын эрэлт хүчтэй өсөж байгаа нь импортыг өсгөж, экспортыг буурахад нөлөөлсөн. Геополитикийн тодорхой бус байдал болон долларын чангаралт нь АНУ-ын эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж болзошгүй.



ДНБ 1.4%-иар буурсан боловч өрхийн худалдан авалт 2.7%-иар өсжээ.

Эх сурвалж: [www.edwardjones.com](http://www.edwardjones.com)

# ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

## Цаашдын төлөв

Хөрөнгийн зах зээл он гарснаас хойш доод түвшиндээ хүрсэн тул хөрөнгө оруулагчдын хандлага тааруу байгаа нь ханшийн хэлбэлзэл өндөр байхад нөлөөлж байна. 5 сарын 11-нд болох ХНС-ийн хурлаар ямар шийдвэр гарах нь хөрөнгийн зах зээлд хүчтэй нөлөөлж магадгүй.

Шинжээчдийн таамаглаж байгаагаар энэ жил ХНС бодлогын хүүг 3 удаа 0.5%-иар өсгөнө гэсэн хүлээлттэй байгаа ба ХНС өөрийн эзэмшиж буй бондын үлдэгдлээ бууруулах хандлагатай байгаа талаар онцолж байна.

Өнгөрсөн 7 хоногт эдийн засаг 1.4%-иар агшсантай холбоотой мэдээгээр хөрөнгө оруулагчид safe haven-рүү илүү зүглэсэн нь бондын өгөөжийг өсөхөд нөлөөлжээ. ХНС-аас явуулсан сүүлийн 4 хатуу мөнгөний бодлогын үеийг авч үзэхэд, 10 жилийн хугацаатай засгийн газрын үнэт цаасны **өгөөж** бодлогын хүүг сүүлийн удаагаа өсөхөөс ойролцоогоор 2 сарын өмнө дээд хэмжээндээ хүрсэн тул үнэт цаасны өгөөж 2023 оны хагас хүртэл өсөж 3.0%-3.5% хүрэх хандлагатай байна.

ХНС-ийн хатуу мөнгөний бодлого баримталсан хугацаа	10 жилийн хугацаатай үнэт цаасны өгөөж оргилд хүрсэн огноо	Хамгийн сүүлд ХНС бодлогын хүүг өсгөсөн огноо	ХНС бодлогын хүүг өсгөснөөс хойш үнэт цаасны өгөөж оргил цэгтээ хүрсэн хоног
1994-1995	1994-11-07	1995-02-01	86 хоног
1999-2000	2000-01-20	2000-05-16	117 хоног
2004-2006	2006-06-29	2006-06-29	0 хоног
2015-2018	2018-11-08	2018-12-20	42 хоног
		<b>Дундаж өдөр</b>	<b>61 хоног</b>

Эх сурвалж: [www.edwardjones.com](http://www.edwardjones.com)